

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заасан.

Монгол Улсын НҮБ-д гишүүнээр элсэн Хүний эрхийн тунхаглалыг бүрэн хүлээн зөвшөөрч, улмаар “Иргэний болон улс төрийн эрхийн тухай”, зэрэг хүний эрхийн талаарх НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудын олон улсын 30 гаруй гэрээнд нэгдэн орж, хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх үйлсэд зохих амжилт олсоор ирсэн. Үүний хүрээнд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор баталсан “Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчдын талаарх үндсэн зарчмын тухай тунхаглал”-д тулгуурлан Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.² Уг хөтөлбөрийн 2.1.5-д дараах байдлаар тодорхойлсон:

- “зохих сан бий болгох, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах даатгалд хамруулах эдгээр гэмт хэргийн улмаас учирсан **хохирлыг нөхөн төлүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж**, эхний ээлжид хариуцагч нь тодорхойгүй, эсхүл төлбөрийн

¹ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 оны №1

² “Монгол Улсад хүний эрхийн хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоол, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2003 он №42, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=6265>

чадваргүй иргэдийн хохирлыг төр урьдчилан төлж, хариуцагчаар нөхөн төлүүлэх журмыг хуулиар тогтоон хэрэгжүүлж цаашид боловсронгуй болгоно.

Гэмт этгээдийн үйлдсэн хэргийн улмаас бусдад учруулсан **хохирлыг нөхөн төлүүлэх нөхцөлийг бий болгох** үүднээс хоригдлыг ажлаар хангах, тэдний хийж гүйцэтгэсэн ажлын хөлсийг ижил төрөл, хэмжээний ердийн ажил, үйлчилгээний хөлс, үнэлгээний дунджаас багагүй байхаар тогтоохын зэрэгцээ тэдэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан “Хохирол нөхөн төлүүлэх эрх”- ийг хангах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааны үндэс нь хохирлын төрөл, хэмжээг тогтоох, үнэлэх асуудал юм.

Харин Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас тодорхой төрлийн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтэл учирсан хохирогчид шүүхийн шийдвэр гарсны дараагаар нөхөн төлбөр олгох зохицуулалттай байна.

Түүнчлэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйл болон 10 дугаар зүйлд зааснаар санхүүжилтийн эх үүсвэр нь шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө, энэ хуульд заасан 18 зүйлийн гэмт хэрэгт гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөр, улсын төсөв байхаар заасан байна.

Гэтэл дээрх сангаас зөвхөн шүүхийн шийдвэр гарсны дараа хохирлын нөхөн төлбөрийг олгохоор заасан нь дээрх бодлогын баримт бичигтэй нийцэхгүй байгаа бөгөөд гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийг хангах, түүнийг нөхөн сэргээх байдал хангалтгүй байгаа үүднээс энэхүү харилцааг зохицуулах шаардлага үүссэн байна.

Иймд хүний зөрчигдсөн эрхийг хамгаалах механизмын нэг хэлбэр болох гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, үнэлэх, нөхөн төлүүлэх үндэсний тогтолцоо бүрдүүлэх нь тулгамдсан асуудал болсоор байна.

1.2 Практик шаардлага

Монгол Улсын хэмжээнд 2012 онд 22089, 2013 онд 25362, 2014 онд 27318, 2015 онд 27757, 2016 онд 27167, 2017 онд 32259, 2018 онд 36220, 2019 онд 31524, 2020 онд 23064, 2021 онд 25429, 2022 онд 35340³, 2023 онд 35574, 2024 онд 44673 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна.⁴

2024 онд гарсан нийт 44673 гэмт хэргийн 191 буюу нийт гэмт хэргийн 0.4 хувь нь Хүнийг алах гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл/, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 8935 буюу нийт гэмт хэргийн 20 хувь, үүнийг задлан дурдбал Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах /Эрүүгийн хуулийн 11.3/

³ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, 2022 онд, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл

⁴ Цагдаагийн байгууллагад 2024 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ, тайлан 2024 он, Цагдаагийн ерөнхий газар, <https://strategy.police.gov.mn/resource/information/File/2025/01/06/6c3do9phniwnbgiv/%D0%A5%D1%8D%D1%80%D1%8D%D0%B3.pdf>

76 буюу нийт гэмт хэргийн 0.17 хувь, Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах /Эрүүгийн хуулийн 11.1/ гэмт хэрэг 350 буюу нийт гэмт хэргийн 1 хувь бол Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах /Эрүүгийн хуулийн 11.4/ гэмт хэрэг 967 бүртгэгдсэн буюу нийт гэмт хэргийн 2.1 хувь байна. Харин мөн онд 658 хүчиндэх гэмт хэрэг гарсан нь нийт гэмт хэргийн 1.5 хувь бол 15889 залилах гэмт хэрэг нь нийт гэмт 35.9 хувийг эзэлж байна.⁵

Түүнчлэн 2022 онд гарсан нийт 35340 гэмт хэргээс 199 буюу нийт гэмт хэргийн 0.6 хувь нь Хүнийг алах гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл/, 818 гэмт хэрэг буюу нийт гэмт хэргийн 2.6 хувь нь Хүний биед хүндэвтэр гэмтэл учруулах гэмт хэрэг, 441 буюу 1.2 хувь нь хүний биет хүнд гэмтэл учруулах гэмт хэрэг байна. Мөн нийт 550 хүчиндэх гэмт хэрэг гарсан нь нийт гэмт хэргийн 1.5 хувь бол 11839 залилах гэмт хэрэг нь нийт гэмт 33.5 хувийг эзэлж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10.3-т заасан нийт 21 гэмт хэргээс 5 төрлийн гэмт хэргийг авч үзэхэд сүүлийн 3 жилд буюу 2024 онд 44673, 2023 онд 35574, 2022 онд 35340 гэмт хэрэг бүртгэгдсэн бол үүнээс 1821-2734 гэмт хэрэг нь хүнийг алах, хүний биед хүнд гэмтэл учруулах, хүний биед хүндэвтэр гэмтэл учруулах, дээрэмдэх, хүчиндэх нийтлэг гардаг 5 төрлийн гэмт хэрэг байна.(хүснэгтээс үзнэ үү) Өөрөөр хэлбэл, эдгээр 5 төрлийн гэмт хэргийн хохирогчид дээрх сангийн хөрөнгөөс нөхөн төлбөрөө голлон гаргуулдаг байна.⁶

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10.3 дугаар зүйлд заасан Гэмт хэргийн нөхөн төлбөр олгох сан сүүлийн 5 жилд гэмт хэрэг бүртгэгдсэн байдал.

	Гэмт хэргийн төрөл	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
№	Бүртгэгдсэн гэмт хэрэг	31524	23064	25429	35340	35574	44673
1.	Хүнийг алах 10.1	197	192	194	199	199	191
2.	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах 11.1	238	301	370	411	359	350
3.	Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах 11.4	319	523	607	760	694	967
4.	Хүчиндэх 12.1	481	401	439	550	564	658
5.	Дээрэм 17.2	868	404	366	485	392	568
	Нийт	2103	1821	1976	2405	2208	2734

Сүүлийн 2013 оноос 2024 оныг дуустал нийт 11 жилийн хугацаанд нийт 516 төлбөр авагч хүсэлт гаргаснаас Эрүүгийн хуулийн дээрх 5 гэмт хэргийн төрлөөр гэмт хэргийн хохирогчид нийт **3 251 469 994** төгрөгийн нөхөн төлбөр авсан байдаг.

Тухайлбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2021 онд 56 хүн хүсэлт гаргаж гэмт хэргийн хохирогчийн нөхөн төлүүлэх сангаас 348 гаруй сая төгрөг хохирлын мөнгөн төлбөр болгон авсан байна. Үүнээс (21.4%) гэмт хэрэгтэн буцаан төлөлт хийсэн

⁵ Цагдаагийн байгууллагад 2024 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ, тайлан 2024 он

⁶ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 зүйл /гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан/ болон түүнд холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, 2024 он.

бөгөөд одоогоор буцаалт төлөлт хийгдсээр байна. 2022 онд нийт 61 хүн хүсэлт гаргаж, 493 сая төгрөгийн хохирол гаргуулж, 361 гаруй сая төгрөгийн нөхөн төлүүлэлт хийсэн байна. Эрүүгийн хуулийн гол үзэл санаа болох хохирогчийн эрхийг хангах, хохирол хор уршгийг арилгах талаар зохицуулсан Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйл гэмт хэргийн хохирол, хор уршиг, Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйл болох Гэм буруугаа хүлээсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын талаарх зүйл, хэсэг заалтууд нь бодитоор хэрэгжиж эхэлсний эерэг үр дагавар гэж дүгнэж болохоор байна.

Гэмт хэргийн улмаас бусдын эрүүл мэндэд гэм хор учирсан бол гэм буруутай этгээд Иргэний хуулийн 505, 506 дугаар зүйлүүдэд зааснаар хохирогчийн эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвар алдсанаас олох байсан орлогын хэмжээгээр хохирлыг нөхөн төлнө. Олох байсан орлогын хэмжээг авах байсан цалин, орлого, авсан тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүгээр тооцох тул хөдөлмөрийн чадвар алдсан этгээдийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ ихсэх, багасах тохиолдолд гэм хор учруулсны төлбөр Иргэний хуулийн 507 дугаар зүйлд зааснаар өөрчлөгдөнө. Эд хөрөнгөд учруулсан гэм хорыг тухайн эд хөрөнгийг бүрэн бүтэн буцаан өгөх, эсхүл Иргэний хуулийн 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах, мөнгөөр учирсан хохирлыг нөхөн төлөх зэрэг аргаар арилгана.

НҮБ-аас олон улсын хамтын нийгэмлэг, засгийн газруудад гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх, шударга ёсыг хангахад чиглэсэн хүчин чармайлт гаргахад нь туслах зорилгоор хууль, олон улсын гэрээний хэм хэмжээний адил дагаж мөрдөх зайлшгүй шаардлагагүй боловч НҮБ-аас тогтоосон бусад норм, стандарттай адилтган үзэх боломжтой зарчим гаргасан бөгөөд тус зарчимд гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн эрхийг хангахад баримтлах үндсэн стандарт болж байгаа юм.

НҮБ-аас энэхүү зарчим, стандартыг тогтоохдоо “гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчтой шударга харьцах”, “гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийг хамгаалалтын механизмд хамааруулах боломжоор хангах”, “мэдээлэл гаргаж өгөх эрхээр хангах”, “айлган сүрдүүлэлтээс хамгаалах”, “хохирогчийн эрхийг хамгаалах албан бус механизм ажиллуулах”, “**хохирол арилгуулах, нөхөн төлбөр, нийгмийн халамжийн тусламж авах эрхээр хангах**” зэргийг тулгуур үндэслэл болгосон байх “гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох” ажиллагааны үргэлжлэл болох “хохирол арилгуулах” асуудлыг багтаасан байна. Уг зарчмыг дэлгэрүүлэн дүн шинжилгээ хийж үзэхэд гэмт хэргийн улмаас учирсан бие махбодын ба сэтгэцийн гэмтэл, сэтгэл зүйн хор уршиг, алдагдсан орлого, эмчилгээний төлбөр, мөн төрөөс тогтоосон нийгмийн халамжийн тогтолцооноос нөхөн төлбөр авах чиглэл, хандлагыг олон улсын түвшинд тогтоосон байна.

Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн үйл явц, шинээр батлагдсан хууль тогтоомжийн үзэл баримтлалыг авч үзэхэд, хүний эрүүл мэндийн хохирлыг бие махбодын болон сэтгэл санааны хохирол хэмээн ангилан тогтоож, мөнгөн хэлбэрээр үнэлэхээр зохицуулжээ. Хүний эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол санаатай учруулсан хэргийг түүвэрлэн судлахад хохирогчийн нэхэмжилсэн хэмжээгээр, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн зардлаар, гэмтлийн зэрэг тогтоосон шинжээчийн дүгнэлтээр, эсхүл цаашид гарах эмчилгээний зардлыг тооцсоноор гаргасан байх бөгөөд зарим хэрэгт эрүүл мэндэд учирсан хохирлыг тооцож, үнэлээгүй байсан.

Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлтээс үзвэл хохирогчдын нэг хэсэг нь гэмтэл авсан эд эрхтнээ өөрсдийн үзэмжээр үнэлж, чанартай улсын болон хувийн эмнэлгүүдэд эмчилгээ хийлгэн холбогдох нотлох баримтуудыг цуглуулан өгч, тэр хэмжээгээр хохирлоо гаргуулан авч чадаж байгаа бол, нөгөө хэсэг нь хохирлоо хэрхэн яаж гаргуулах, баримтуудыг хэрхэн яаж бүрдүүлэх талаар мэдлэг дутмаг, зөвхөн эмчилгээний зардлаа л нэхэмжилж, хохирлоо бага хэмжээний мөнгөн дүнгээр төлүүлэн хоцорч байна. Өөрөөр хэлбэл, эрүүл мэндэд учирсан хохирлын жишиг үнэлгээ байхгүй тул хэн эмчилгээ хийлгэж, баримт цуглуулж чадсан нь хохирлоо тогтоолгодог практик тогтсон.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах асуудлыг хуульчлан зохицуулалт дутуу, энэ талын практик бага тул гадаад улсын хууль тогтоомж, практик, олон улсын чиг хандлагыг судлах замаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д заасан “төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах” үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Тодруулбал, гэмт хэргийн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, учирсан хохирол, хор уршгийг шударгаар барагдуулах үндэсний тогтолцоог нэн даруй бүрдүүлэх шаардлагатай байна.

Мөн “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай” Палермогийн протоколд зааснаар гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг гэмт хэргийн хохирлыг барагдуулахад зарцуулахаар заасан байдаг. Гэвч Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 3-т “Хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирлоос илүү гарсан тохиолдолд **улсын төсөвт шилжүүлнэ.**” гэж заасан байна. Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 4-т “Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна.” гэж заасан байна. Үүнээс үзэхэд гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулснаас үлдсэн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлэхээр заасан.

Мөн үндэслэлгүйгээр хөрөнгөжих болон авлигын гэмт хэрэгт бодит хохирол гарахгүй байх боломжтой бөгөөд тухайн авлигын гэмт хэргээс хураагдсан эд зүйлийг улсын төсөвт шууд шилжүүлэх эрх зүйн зохицуулалттай байна. Гэтэл Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох санд хөрөнгө төвлөрүүлсэн тоо мэдээнээс үзэхэд улсын төсвөөс энэ санд хөрөнгө ордоггүй байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хохирлыг барагдуулах зарчимтай хөрөнгө улсын төсвөөр дамжин уг санд ордоггүй байна.⁷

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, сүүлийн 5 жилд хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан хүнээс 22,4 тэрбум төгрөгийг улсын орлогод

⁷ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйл /гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан/ болон түүнд холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 2025 он

төвлөрүүлсэн байна.⁸ Түүнчлэн Авлигатай тэмцэх газраас 2 их наяд 374 тэрбум төгрөгийн авлигын гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулсан байна.

Үүнээс үзэхэд хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээнээс болон авлигын гэмт хэргээс учирсан хохирлыг Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох санд төвлөрүүлэн хохирлыг барагдуулах нь бүрэн боломжтой гэж үзэж байна.

Дээрх хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагад үндэслэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлсон болно.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1 дүгээр зүйлд заасныг үндэслэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлно:

-Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн нэрийг Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сан гэсэн өөрчлөлтийг тусгана;

- Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангаас олгох сангийн хөрөнгийн эх үүсвэрийг “гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг гэмт хэргийн хохирлыг барагдуулахад зарцуулах” зарчмыг үндэслэн нэмэгдүүлэх, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох зохицуулалтыг тусгана;

- Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангийн хөрөнгөөр шүүхийн шийдвэр гарахаас өмнө нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ;

- Шүүхийн шийдвэрийг үндэслэн, эсхүл шүүхийн шийдвэр гарахаас өмнө Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангийн санхүүжилтээр олгох Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн жагсаалтыг ялгамжтай байдлаар тодорхойлно;

- Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр “Тусгай сангийн хөрөнгөөр гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийг хохирогчид шууд олгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

- Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангийн удирдлага, зохион байгуулалтын оновчтой хэлбэр, хяналтын эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

- Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангаас зарим төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд шаардлагатай зардлыг гаргах зохицуулалтыг тусгана. Тухайбал, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгахад шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд

⁸ Хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээний сүүлийн 5 жилийн хэрэгжилтын тайлан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, 2023 он

оролцох хэлмэрчид төлөх зардал зэргийг уг сангаас санхүүжүүлэх зохицуулалтыг тусгана;

- Гэмт хэргийн хохирлыг нөхөн барагдуулах сангаас хохирогчийн хохирлыг барагдуулахад зарцуулсан хөрөнгийг буруутай этгээдээс гаргуулах ажлыг сан хариуцан зохион байгуулахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаах авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж тооцоолж байна.

- Хуулийн төсөл батлагдсанаар гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн барагдуулах боломж нэмэгдэж, Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх эрхийг хангахад томоохон дөхөм болно;

- Гэмт буруугийн шүүхийн шийдвэр гарахаас өмнө тухайн гэмт хэргийн хохирогчийн эрүүл мэндэд учирсан хохирлыг нэн яаралтай барагдуулах, эрүүл мэндийн хохирлыг арилгах тусламж үйлчилгээнд зарцуулснаар тухайн хохирогчид учирч болох эрүүл мэндийн хохирлыг бууруулах, амь насыг аврах нэн яаралтай тусламж үйлчилгээг үзүүлэх боломж бүрдэнэ;

- Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр бий болно;

- Гэмт хэргийн улмаас хураагдсан эд зүйлийг гэмт хэргийн хохирлыг барагдуулахад зарцуулах эрх зүйн орчин сайжирна.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар.

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль зэрэг холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

Хуулийн төслийг дагалдуулан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

----oOo----